Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 76,703.2 мянган төгрөгөөр буюу 8.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
	Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		0.0	0.0	0.0
Авлага		88,427.80	39.4	-88,388.40
Бараа материал		38,974.8	53,583.9	13,609.1
Үндсэн хөрөнгө		818,098.3	815,178.0	-2,920.30
Нийт хөрөнгө		945,504.5	868,801.3	-76,703.20
Өр төлбөр		618.7	1,363.6	744.90
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/		944,885.7	867,437.7	-77,448.00
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн		945,504.5	868,801.3	-76,703.20

Авлага дансны үлдэгдэл 39.4 мянган төгрөг болж буурсан нь 68,880.0 мянган төгрөгийн лабораторийн тоног төхөөрөмж хүлээн авсан, 19,547.8 мянган төгрөгийн төлбөртэй үйлчилгээний авлага барагдсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 53,583.9 мянган төгрөг болж 13,609.1 мянган төгрөгөөр өссөн нь лабораторид ашиглагдах бусад хангамжийн материал худалдан авсантай холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй болно.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 815,178.0 мянган төгрөг болж 2,920.3 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

Өр төлбөр данс нь 744.9 мянган төгрөгөөр өссөн нь түлш, халаалтын зардлын өглөг үүссэнээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 867,437.7 мянган төгрөг болж 77,448.0 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 701,950.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийн 131,830.2 мянган төгрөгөөр бууруулан 570,120.7 мянган төгрөгөөр баталсныг төсвийн тодотгол хийгдэж 16,769.1 мянган төгрөгөөр бууруулж 553,351.6 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотголоор өөрчлөлт ороогүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 570,120.7 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 553,351.6 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 527,036.6 мянган төгрөг буюу 95.2 хувьтай байна. Үндсэн үйл ажиллагааны зардлаас 26,314.9 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	507,216.4	482,714.6	24,501.7	95.1%
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	23,176.9	21,371.4	7.6	99.9%
3	Барилгын техник хяналт	22,958.3	22,950.6	1,805.5	92.2%

Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардал 21,063.8 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал нь 2,271.5 мянга, эд хогшил худалдан авах зардал 764.0 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал 1,805.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн

гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 304,659.9 мянган төгрөгийн орлого орсон байна.

Үүнээс хангамжийн бараа материалын зардалд 56,793.0 мянга, эд хогшил худалдан авах зардалд 19,056.7 мянга, томилолтын зардалд 6,912.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардалд 29,019.7 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 55,664.5 мянга, нэг удаагийн урамшууллын зардалд 720.0 мянга, хөрөнгийн зардалд 68,880.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 67,613.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Нанжидмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 32 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 806,659.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 8,066.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2022

оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 853,262.2 мянган төгрөгийн 1 хувь 8,532.6 мянган төгрөгөөс 80 хувиар буюу 6,826.0 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга нь батлагдсан орон тоог хэтрүүлэн нярав-жолооч нэмж /шинээр томилогдсон албан хаагчид томилсон тушаал байхгүй/ ажиллуулан төсвөөс 4,215.6 мянган төгрөгийн цалинг олгосон, Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 8,170.3 мянган төгрөгийн төлбөрийн актыг цалингийн зардлаас төлсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.2.2 дахь заалтад “Хуулиар зөвшөөрөөгүй бусад”, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно” 15.1.2 дахь заалтад “Чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох” гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 149 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Тус байгууллага нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

2. Гэрээ байгуулан ажиллуулсан 9 ажилтны нийгмийн даатгалын шимтгэлийн суутган тооцоогүй нь байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт “Дараах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна” 32.1.2 дахь заалтад “Иргэний хуулийн 343, 359 дүгээр заасан гэрээгээр тохирсон хөлс” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга нь батлагдсан орон тоог хэтрүүлэн нярав-жолооч нэмж /шинээр томилогдсон албан хаагчид томилсон тушаал байхгүй/ ажиллуулан төсвөөс 4,215.6 мянган төгрөгийн цалинг олгож төрд хохирол учруулсан зөрчил илэрсэн болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 79,250.2 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 3,993.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1,314.0 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн байна. Ирүүлсэн нотлох баримт биелэлтийг хянаж үзэхэд 8,170.3 мянган төгрөгийн 1 төлбөрийн актыг төсвөөс төлсөн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	79,250.2	2	71,079.9	66
Албан шаардлага	1	3,993.0	1	3,993.0	100
Зөвлөмж	1	1,314.0	1	1,314.0	100
Нийт дүн	5	84,557.2	4	76,386.9	91.5

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын тээвэр шатахууны зардлын зарцуулалтад биет горим сорил хэрэгжүүлж тулган баталгаажуулахад албан ажлаар явсан эсэхийг тогтоох боломжгүй байна. Иймд тээвэр шатахууны зардлыг дараагийн аудитаар нарийвчлан авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 25,009.6 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 12,385.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 2,723.7 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 9,900.0 мянган төгрөгийн зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлээ.

5.1 Төлбөрийн акт

- Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга нь албаны эрх мэдлээ хэтрүүлэн Төрийн аудитын газрын тогтоосон 8,170.3 мянган төгрөгийн төлбөрийн актыг цалингийн зардлаас төлж төрд хохирол учруулсан нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "Төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтад "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1. дэх хэсэгт "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.4 дэх заалтад "Хуулиар зөвшөөрөөгүй бусад", Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5 дахь заалтад "Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу

илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй”, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 39.1.2 дахь заалтад “Албаны эрх мэдлээ хэтрүүлэхийг хориглоно” гэж тус тус заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2. Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга нь батлагдсан орон тоог хэтрүүлэн нярав-жолооч нэмж /шинээр томилогдсон албан хаагчид томилсон тушаал байхгүй/ ажиллуулан 4,215.6 мянган төгрөгийн цалинг олгож төрд хохирол учруулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.2 дахь заалтад “Төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх”, 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалтад “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 39.1.2 дахь заалтад “Албаны эрх мэдлээ хэтрүүлэх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.4 дэх заалтад “Хуулиар зөвшөөрөөгүй бусад”, 15 дугаар зүйл 15.1. дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.2 дахь заалтад “Чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох”, Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь заалтад “Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах эрх хэмжээтэй байна”, 23.2.6 дахь заалтад “Засгийн газраас тогтоосон хязгаарт багтаан аймаг, нийслэл, дүүргийн газрын албаны бүтэц, орон тоог батлах”, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2019 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн Б/123 дугаар тушаалын 18 дугаар хавсралтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

5.2 Албан шаардлага

1. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын зардлаас 2,723.7 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтад “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, Барилга хот байгуулалтын сайдын 2022 оны 83 дугаар тушаалыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

5.4 Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал

1. Ланд-200 маркын автомашины 9,900.0 мянган төгрөгийн автомат кроп сольсон байна. Ланд-200 маркын автомашины автомат кроп сольсныг нотлох засвар үйлчилгээ хийлгэсэн авто засварын газрын оношилгооны дүгнэлт байхгүй бөгөөд дараах баримтуудын мэдээлэл зөрүүтэй байна. Үүнд:

- Өмч хамгаалах зөвлөлийн тэмдэглэлд дурдсан спидометрийн заалт,
- Жолоочтой хийсэн ярилцлагын тэмдэглэлд дурдагдсан автомашины эвдэрсэн газрын байршил,
- Жолоочийн замын тооцооны хуудасны спидометрийн заалт

Шийдвэрлэсэн нь: Хууль хяналтын байгууллагад шилжүүлэх.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга нь албаны эрх мэдлээ хэтрүүлэн Төрийн аудитын газрын тогтоосон төлбөрийн актыг төсвийн хөрөнгөөс төлж төрд хохирол учруулсан.	1	8,170.3	1	8,170.3								
Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга нь батлагдсан орон тооноос хэтрүүлэн нярав-жолооч нэмж /шинээр томилогдсон албан хаагчид томилсон тушаал байхгүй/ ажиллуулан цалин олгож төрд хохирол учруулсан.	1	4,215.6	1	4,215.6								
Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын зардлыг зориулалт бусаар зарцуулсан.	1	2,723.7			1	2,723.7						
Ланд-200 маркын автомашины автомат кроп сольсныг нотлох засвар үйлчилгээ хийлгэсэн авто засварын газрын оношилгооны дүгнэлт байхгүй анхан шатны баримтуудын мэдээлэл зөрүүтэй байна	1	9,900.0									1	9,900.0
Дүн	4	25,009.6	2	12,385.6	1	2,723.7					1	9,900.0

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

/А.НАНЖИДМАА/

2023 оны 02 дугаар сарын 16-ны өдөр



УВСАЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 01/08/А.2070416
УВА 2023/36/НА-СНН-ТМЗ

Улаангом

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга нь албаны эрх мэдлээ хэтрүүлэн Төрийн аудитын газрын тогтоосон 8 170 291 төгрөгийн төлбөрийн актыг цалингийн зардлаас төлж төрд хохирол учруулсан зөрчил илэрлээ.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтад “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1. дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.4 дэхь заалтад “Хуулиар зөвшөөрөөгүй бусад”, Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5 дахь заалтад “Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй” Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйл “Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 39.1.2 дахь заалтад “Албаны эрх мэдлээ хэтрүүлэхийг хориглоно” гэж тус тус заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төсвөөс төлсөн төлбөрийн актын төлбөр 8 170 291 / Найман сая нэг зуун далан мянга хоёр зуун ерэн нэг/ төгрөгийг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Отгонболдоор төлүүлж Төрийн сан банкин дахь Орон нутгийн орлогын 100150000962 тоот дансанд төвлөрүүлэх.

- Актын биелэлтийг 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Отгонболд, нягтлан бодогч А.Бадамсүрэн нарт хариуцуулав.
- Төлбөрийн актыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР



А.НАНЖИДМАА

АУДИТЫН МЕНЕЖЕР



М.БАТ-АМГАЛАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ



УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 02/09/А.2023/016

Улаангом

УВА-2023/36/НА-СГА АУС

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга нь батлагдсан бүтэц орон тоог хэтрүүлэн нярав-жолооч нэмж /шинээр томилогдсон албан хаагчид томилсон тушаал байхгүй/ ажиллуулан 4215630 төгрөгийн цалинг олгож төрд хохирол учруулсан зөрчил илэрлээ.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.2 дахь заалтад "Төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх", 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалтад "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт "Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно", 39.1.2 дахь заалтад "Албаны эрх мэдлээ хэтрүүлэх", Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь заалтад "Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах эрх хэмжээтэй байна", 23.2.6 дахь заалтад "Засгийн газраас тогтоосон хязгаарт багтаан аймаг, нийслэл, дүүргийн газрын албаны бүтэц, орон тоог батлах", Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2019 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн Б/123 дугаар тушаалын 18 дугаар хавсралтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.6-д "Эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" гэж заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Батлагдсан орон тоог хэтрүүлэн ажиллуулж нярав-жолоочийн цалинд олгосон 4215630 /Дөрвөн сая хоёр зуун арван таван мянга зургаан зуун гуч/ төгрөгийг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Отгонболдоор төлүүлж Төрийн сан банкин дахь Орон нутгийн орлогын 100150000962 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Отгонболд, нягтлан бодогч А.Бадамсүрэн нарт хариуцуулав.
3. Аудитаар өгсөн албан шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР



А.НАНЖИДМАА

АУДИТЫН МЕНЕЖЕР



М.БАТ-АМГАЛАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ



УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 01/11/А2023/0416
УВА-2023/36/НА-СГА АУС

Улаангом

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын зардлаас 2,723,750 төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтад “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, Барилга хот байгуулалтын сайдын 2022 оны 83 дугаар тушаалаар батлагдсан “Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын зардлаас санхүүжүүлэх зардлын нэр төрөл” журмыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалтад “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” 4.2.1.6-д “Төсвийг зориулалт бусаар зарцуулсан” гэж заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын зардлаас зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газар² т ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга Г.Отгонболд, нягтлан бодогч А.Бадамсүрэн нарт даалгав.


²Увс аймаг, Улаангом сум, 3 дугаар баг, Ө.Бадрахын гудамж, аймгийн Засаг Даргын Тамгын газрын байр, 304 тоот, Утас: 70453317

0200400228

3. Аудитаар өгсөн албан шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР



А.НАНЖИДМАА

АУДИТЫН МЕНЕЖЕР



М.БАТ-АМГАЛАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ